



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 16 өдөр

Дугаар A/273

Булган сум

┌ “Wanderlast Mongolia” нүүдлийн театрын ┐
арга хэмжээний зардалд хөрөнгө
гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” A/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүүхэд, залуучуудад соёл, урлагийн боловсрол олгох, олон улсын театрын уран бүтээлийг сурталчлан таниулах зорилгоор 2026 оны 04 дүгээр сарын 19-ны өдрөөс 24-ны өдрүүдэд 16 сум 1 тосгонд нүүдлийн театрын үзвэр үйлчилгээг иргэдэд хүргэх баг, бүрэлдэхүүний шатахуун, унаа, зохион байгуулалтын зардалд 10,591,400 (арван сая таван зуун ерэн нэгэн мянга дөрвөн зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын “Бүх нийтийн соёлын боловсрол олгох төлөвлөгөө”-ний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д. ПҮРЭВ-ОЧИР



6326010378

Аймгийн Засаг даргын 2026 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар захирамжийн хавсралт



**“Wanderlast Mongolia” нүүдлийн театрын
арга хэмжээнд шаардагдах шатахуун,
зохион байгуулалтын төсөв**

Д/д	Зардлын нэр	Шатахууны төрөл	Норм (100км-т)	Туулах километр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Хойд бүс (Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг) Булган-Орхон-Булган аймаг							
1.	Автобус (Булган сум)	Дизель	25	760.0	л	4,680	889,200
2.	Пургон (СУАЖЗГ)	АИ92	18	760.0	л	2,720	372,096
3.	Портер	Дизель	15	760.0	л	4,680	533,520
4.	Портер түрээс (АЗДТГ)	-	-	-	5 өдөр	100,000	500,000
5.	Суудлын автомашин (ХЖТ)	АИ92	15	760.0	л	2720	310,080
Нийт						2,604,896	
Урд бүс (Дашинчилэн, Баяннуур, Рашаант, Гурванбулаг) Булган-Орхон аймаг							
1	Пургон (боловсролын газар)	Дизель	18	720	л	4,680	606,528
2	Pgado 150 суудлын автомашин (ХЖТ)	АИ92-Евро	18	720	л	3,200	414,720
3	Портер	Дизель	15	720	л	4,680	505,440
Нийт						1,526,688	
Wanderlast (Медиа баг- Баяннуур, Хишиг-Өндөр, Хангал, Тэшиг)							
1	Суудлын автомашин (төслийн баг)	АИ92	10	1,080	л	2,720	293,760
2	Суудлын автомашин (төслийн баг)	АИ92	7	800	л	2,720	152,320
Нийт						446,080	
Урд бүс (Орхон, Могод, Бүрэгхангай, Хишиг-Өндөр) Булган-Орхон-Булган аймаг							
1	Пургон (байгаль орчин)	АИ92	17	810	л	2,720	374,544
2	Хайс (Стандарт хэмжилзүйн хэлтэс)	Дизель	17	810	л	4,680	644,436
3	Пургон (БТСГ)	АИ92	18	810	л	2,720	396,576
4	Портер	Дизель	15	810	л	4,680	568,620
5	Портер түрээс	-	-	-	5 өдөр	150,000	750,000
6	Суудлын автомашин (ХЖТ)	АИ92	15	810	л	2,720	330,480
Нийт						3,064,656	
Хойд бүс (Сэлэнгэ, Хангал, Хялганат, Бугат)							
1	Автобус (хжт 22 хүний суудалтай)	Дизель	25	446.0	л	4,680	521,820
2	автобус (Хангал сум 12 хүний суудалтай)	Дизель	25	506.0	л	4,680	592,020
3	Портер	Дизель	13	446.0	л	4,680	271,400

4	Суудлын автомашин (ХЖТ 2 хүн)	АИ92	12	446.0	л	2,720	145,600
5	Портер түрээс	-	-	-	5 өдөр	150,000	750,000
Нийт						2,280,840	
Нийт дүн						9,923,160	
Зохион байгуулалтын зардал							
Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ		
1.	Гадна аннос /Өргөн 2,50 Урт 3/	ш	2	146,000	292,000		
2	Гадна карказ бүрэх /урт 9 өргөн 40/	ш	1	83,800	83,800		
3	Босоо карказ /Өндөр 4,50 Өргөн 40/	ш	2	42,400	84,800		
4	Карказны 2 тал /70*70/	ш	2	11,820	23,640		
5	Тайзны урд тал /Өндөр 90 Урт 10/	ш	1	184,000	184,000		
Нийт дүн						668,240	
Бүгд дүн						10,591,400	

---oOo---